

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1998 оны “Журам батлах тухай” 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх ард түмний 14 дүгээр их наадам, Иргэдийн спортын 5 дугаар их наадмуудад идэвхтэй оролцож, амжилт гаргасан пара тамирчид болон хороодын иргэдийг шагнуулахаар ирүүлсэн Биеийн тамир спорт хорооны хүсэлтийг харгалзан хавсралтанд нэр дурьдсан пара тамирчид болон иргэдийг дүүргийн Засаг даргын шагналаар шагнасугай.

2. Шагналд зарцуулагдах хөрөнгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хянан ажиллахыг Засаг даргын Орлогч /Ж.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ